



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/609

Улаанбаатар хот

Нийслэлийн өмчид барилга
байгууламжийг бүртгэн авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 78 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 53 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт, Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж, ашиглалтад орсон болон худалдан авсан нийт 22,124,153,553.40 (хорин хоёр тэрбум нэг зуун хорин дөрвөн сая нэг зуун тавин гурван мянга таван зуун тавин гурван төгрөг дөчин мөнгө) төгрөгийн өртөг бүхий, хавсралтад заасан барилга байгууламжийг нийслэлийн өмчид бүртгэн авсугай.

2.Нийслэлийн өмчид шинээр бүртгэгдэж байгаа 8 барилга байгууламжийг данс бүртгэлдээ бүртгэн авч, ашиглалт, хамгаалалтыг хариуцан ажиллахыг эзэмшигч байгууллагын удирдлага нард үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (В.Оюумаа)-т даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ



Х.НЯМБААТАР

1110202954



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИД БҮРТГЭХ 8 БАРИЛГА БАЙГУУЛАМЖУУДЫН ЖАГСААЛТ

Д/д	Барилга байгууламжийн нэр	Байршил	Барилга байгууламж ашиглалтад орсон огноо	Төсвийн хөрөнгөөр худалдан авсан огноо	Бүртгэх үнэ /төгрөгөөр/	Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Эзэмшигч байгууллага
1	164 дүгээр цэцэрлэгийн Монгол өв уламжлал, ёс заншлын өргөө /100 ор/	Баянгол дүүргийн 4 дүгээр хороо, Ханбүртгэдэй их дэлгүүрийн зүүн талд, 164 дүгээр цэцэрлэгийн хашаанд	2023.12.12		1,043,467,568.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянгол дүүргийн 164 дүгээр цэцэрлэг
2	8 дугаар цэцэрлэгийн барилга байгууламж /240 ор/	Баянзүрх дүүргийн 16-р хороо, 16-р хороолол, Дандарбаатарын 1-р гудамж, Офицеруудын ордны зүүн хойно	2023.06.08		5,512,985,185.40	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгө	Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэг
3	318 дугаар цэцэрлэгийн барилга /240 ор/	Баянзүрх дүүргийн 13-р хороо, Алтан тэвшийн амины орон сууц гудамжинд	2018.11.24	2022.12.08	4,983,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянзүрх дүүргийн 318 дугаар цэцэрлэг
4	320 дугаар цэцэрлэгийн барилга /150 ор/	Баянзүрх дүүргийн 23-р хороо, Хужирбуланд, 87-р сургуулийн урд талд	2016.12.09	2023.06.16	2,073,600,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Баянзүрх дүүргийн 320 дугаар цэцэрлэг
5	145 дугаар цэцэрлэгийн барилга /75 ор/	Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо, Вива сити 3/16 байр 1-1-4 тоот	2013.07.30	2022.12.20	572,700,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн 145 дугаар цэцэрлэг
6	322 дугаар цэцэрлэгийн барилга /100 ор/	Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо, Үйлдвэрийн баруун бүс ажилчны гудамж 80/7 байр 2 тоот	2022.04.18	2023.02.28	1,676,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн 322 дугаар цэцэрлэг

7	324 дугаар цэцэрлэгийн барилга /150 ор/	Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо, Зайсан /17020/ Дунжингарав гудамж 206/2 байр	2018.03.16	2023.02.09	2,862,400,800.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн 324 дүгээр цэцэрлэг
8	325 дугаар цэцэрлэгийн барилга /100 ор/	Хан-Уул дүүргийн 17 дугаар хороо, Стадцион оргил Их монгол улсын гудамж, 100/7 ТООТ	2015.06.16	2022.12.05	3,400,000,000.00	Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалт	Хан-Уул дүүргийн 325 дугаар цэцэрлэг
Нийслэлийн өмчид бүртгэх барилга, байгууламжийн нийт дүн					22,124,153,553.40		

1110202957